**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 05 өдөр                Дугаар А/49                Нарийнтээл сум

Малчдад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын ихэнх нутгаар цас орж хүйтэрч байгаатай холбогдуулан зудын эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Шарга 1-р баг, Өндөрхөмөг 3-р баг, Цагаан-овоо 4-р багуудад малчдын 250 хот айлд (40кг-аар савласан) хивгийг үнэгүй, мөн малчдад 25 кг-тай хивгийг 10,000 төгрөгөөр, өвсийг 10,000 төгрөгөөр тус тус хямдруулан худалдаж малчид, мал бүхий иргэдэд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Уг дэмжлэгийг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Энхжин), Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА                Б.СУГАР

№ G22311105

D.My:Doc.A4Zahiramj /ZD/

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр Дугаар А/50 Нарийнтээл сум

## Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсролын салбарын багш ажилтнуудын аймгийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд Баянтээг багийн багш ажилчдыг оролцуулах зардалд 106.400 (зуун зургаа мянга дөрвөн зуу) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардалд зарцуулах 106.400 төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (П.Сольтогтох)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

622311107

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр Дугаар А/61 Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ахмадын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 15.5, 14.5.2, 14.6, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2023 оны төсөв батлах тухай" 2022 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ахмад настнуудын мод, бут тарьж ургуулах, арчлах үйл ажиллагааны зардалд 1.200.000 ( нэг сая хоёр зуун мянга ) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлыг эрсдэлээс хамгаалах сангийн зохих зардлаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (П.Сольтогтох)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

2023/04/11 52

№ 622311103

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр Дугаар А/52 Нарийнтээл сум

Туслалцаа үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 4 дүгээр багийн иргэн Ц.Санжид, Ц.Батдэлгэр нарын ар гэрт гачигдал гарсан тул оршуулгын зардалд зориулан 436.000 (дөрвөн зуун гучин зургаан мянга) төгрөгийг зарцуулж хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардалд зарцуулах 436.000 төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (П.Сольтогтох)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 12 өдөр Дугаар А/53 Нарийнтээл сум

Туслалцаа үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 3 дугаар багийн иргэн Отгонбор овогтой Алтантуяагийн охин болох А.Батцэцэгийн эмчилгээний зардалд зориулан 100.000 (нэг зуун мянга) төгрөгийг зарцуулсагуй.

2. Дээрх 100.000 төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (П.Сольтогтох)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 12 өдөр Дугаар А/54 Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр суман дахь Ахмадуудын золголтын арга хэмжээний зардалд 239.400 (хоёр зуун гучин есөн мянга дөрвөн зуу) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар батласугай.

2. Дээрх 239.400 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Г.Пүрэвдавга)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

622311115

D.My:Doc.A4Zahiramj /ZD/

Наринтээл сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/54 дүгээр захирамжийн хавсралт

# АРВАЙХЭЭР СУМАН ДАХЬ АХМАДЫН ЗОЛГОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Материалын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ /мян.төг/ | Бүгд үнэ /мян.төг/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Еэвэн | уут | 26,6 | 9000 | 239.400 |
| Дүн | | | | | 239.400 |

_______o0o_______

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 12 өдөр Дугаар А/65 Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.5, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2023 оны төсөв батлах тухай" 2022 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын эрсдлээс хамгаалах сан хариуцсан ажилтны ажиллах нөхцлийг бүрдүүлэх зардалд 3.550.000 ( гурван сая таван зуун тавин мянга) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлыг эрсдэлээс хамгаалах сангийн зохих зардлаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (П.Сольтогтох)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G22311118

Нарийнтээл сумын Засаг даргын 2023
оны 04 дүгээр сарын 10 ны өдрийн А/55
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Материалын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ /мян.төг/ | Бүгд үнэ /мян.төг/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Зөөврийн компьютер | ш | 1 | 3.550.000 | 3.550.000 |
| Дүн | | | | | 3.550.000 |

_______o0o_______

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 13 өдөр Дугаар А/56 Нарийнтээл сум

Цэрэг татлагын комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Ээлжит цэрэг татлага явуулах тухай" А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны ээлжит цэрэг татлагын ажлыг зохион байгуулах сумын комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Б.Ичинноров (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: С.Баасандулам (Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Б.Бат-Эрдэнэ (Эмнэлгийн их эмч)
Г.Билгүүн (Эмнэлгийн эмчлэгч эмч)
М.Долгормаа (Эмнэлгийн эмчлэгч эмч)
Ч.Оюунзул (Архив бичиг хэргийн ажилтан)
Т.Батдулам (Насан туршийн боловсролын нэгжийн багш)
Н.Түмэнжаргал (Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч)
Э.Мөнхбат (Засаг даргын Тамгын газрын нярав)
О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)
Б.Базарсад (2 дугаар багийн Засаг дарга)
О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)
Ц.Мөнх-Эрдэнэ (4 дүгээр багийн Засаг дарга)
Ч.Цэцэгжаргал (Соёлын төвийн номын санч)

2. Цэрэг татлагын ажлыг хуулийн дагуу тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, дүн, мэдээг Засаг даргад танилцуулахыг комиссын дарга (Б.Ичинноров)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

622311119

D.My:Doc.A4Zahiramj /ZD/

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 18 өдөр Дугаар А/57 Нарийнтээл сум

Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.8.1, 9.8.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны "Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай" А/240 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор үхэр сүрэгт дархлаажуулалтын ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ноос 05 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Багийн малчид, иргэдэд дархлаажуулалтын ажлын зар, мэдээллийг цаг тухайд нь хүргэж, хариуцсан багийн мал сүргийг тогтоосон хугацаанд бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Шүлхийн вакцинжуулалтын арга хэмжээг хийж гүйцэтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

4.Шүлхийн вакцинжуулалтанд зарцуулах хөрөнгийн зардлыг малын тоо толгойн албан татварын хөрөнгөөс зарцуулахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

5.Үхэр сүрэгт хийх мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, ажлын явц, үр дүнд хяналт тавьж, дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Бямбадолгор)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G22311121

D.My:Doc.A4Zahiramj /ZD/

Нарийнтээл сумын Засаг даргын 2023
оны 04 дүгээр сарын 18 ны өдрийн А/57 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

## МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)
Гишүүдэд: П.Төмөртогоо (Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)
Д.Цэцгээ (Малын их эмч)
Р.Бат-Эрдэнэ (Малын их эмч)
Г.Батсүх (Малын их эмч)
Ц.Санжид (Малын их эмч)
О.Цэрэннадмид 1 дүгээр багийн Засаг дарга
Б.Базарсад 2 дугаар багийн Засаг дарга
О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)
Ц.Мөнх-Эрдэнэ 4 дүгээр багийн Засаг дарга
А.Батмөнх (жолооч)

______o0o_____

Нарийнтээл сумын Засаг даргын 2023 оны04. дүгээр сарын 18. ны өдрийн А/57 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

# МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЖУУЛАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Бараа материалын нэр | Явах км | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ /мян.төг/ | Бүгд үнэ /мян.төг/ |
|---|---|---|---|---|---|---|
| Бумбат суварга БГБХН /Шарга, Баянтээг баг/ | | | | | | |
| 1 | А-92 | 1200 | Литр | 230 | 2660 | 611800 |
| Бумбат-Ур БГБХН /Өндөр хөмөг, Цагаан-Овоо баг/ | | | | | | |
| 2 | Д түлш | 1000 | литр | 220 | 3930 | 864600 |
| Мал эмнэлгийн тасаг | | | | | | |
| 3 | А-92 | 400 | литр | 100 | 2660 | 266000 |
| Туслах ажилтны хөлс | | | | | | |
| 4 | Ажилчдын тоо | | Хэмжих нэгж | Ажиллах өдрийн тоо | Нэг өдрийн ажлын хөлс | Бүгд үнэ /мян.төг/ |
| 1 | 4 хүн | | Хоног | 10 | 50000 | 2,000,000 |
| Нийт дүн | | | | | | 3,742,400 |

_______о0о______

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 22 өдөр Дугаар А/58. Нарийнтээл сум

Түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны ээлжит цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд ард иргэдийн амгалан тайван байдлыг хангаж ажиллах зорилгоор архины тусгай зөвшөөрөлтэй хүнсний дэлгүүрүүдийг 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн өглөөний 06 цагаас оройн 24 цаг хүртэл архи согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг түр хориглосугай.

2.Аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний газруудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (С.Баасандулам), хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч (Н.Түмэнжаргал), 4 дүгээр багийн Засаг дарга (Ц.Мөнх-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

622311123

D.My:Doc.A4Zahiramj /ZD/

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ**
**НАРИЙНТЭЭЛ СУМЫН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 22 өдөр Дугаар А/59 Нарийнтээл сум

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
мал амьтны сэг зэмийг цуглуулж устгах,
орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн "Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд чанартай зохион байгуулах" тухай 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэижээг зохион байгуулах тухай" А/177 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нийт бэлчээр, уст цэгийг бохирдлоос хамгаалж зүй бусаар хорогдсон мал, амьтдын сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч. Г.Батсүх (Засаг даргын орлогч)
Гишүүдэд: Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)
Г.Наранбаатар (Байгаль орчны мэргэжилтэн)
П.Төмөртогоо (Сумын Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч, малын их эмч)
Б.Шинэбаатар (Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Батнаран (Экологийн асуудал хариуцсан байцаагч)
О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)
Б.Базарсад (2 дугаар багийн Засаг дарга)
О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)
Ц.Мөнх-Эрдэнэ (4 дүгээр багийн Засаг дарга)
Д.Цэцэгээ ("Бумбат суварга" БГБХ нөхөрлөл

2.Малын сэг зэм устгах ажлыг чанартай зохион байгуулж иргэд малчдыг мэдээллээр хангаж хүн, хүч техник хэрэгслийг дайчлан ажиллуулж хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Г.Батсүх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

622311125
D.My:Doc.A4Zahiramj /ZD/

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр Дугаар А/60 Нарийнтээл сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хавсралтанд дурьдагдсан 3 иргэний, 0.2451га/2451.0м²/ газар эзэмших эрхийг 3 иргэнд шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчдэд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал /Н.Мягмаржав/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

G22311127
D.My:Doc.A4Zahiramj /ZD/

Нарийнтээл сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 28 ны өдрийн А/61 дүгээр захирамжийн хавсралт

ОРШУУЛГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Материалын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ /мян.төг/ | Бүгд үнэ /мян.төг/ |
|---|---|---|---|---|---|
| 2 | А-92 бензин | л | 175.18 | 2660 | 466000 |
| | ДҮН | | | | 466000 |

________o0o_______

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 27 өдөр Дугаар А/61 Нарийнтээл сум

Туслалцаа үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 4 дүгээр багийн иргэн Ц.Санжид, Д.Батбаатар нарын ар гэрт гачигдал гарсан тул оршуулгын зардалд зориулан 466.000 (дөрвөн зуун жаран зургаан мянга) төгрөгийг зарцуулж хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардалд зарцуулах 466.000 төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

622311129

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 28 өдөр Дугаар А/62 Нарийнтээл сум

Барааны гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих Сумын Эрүүл мэндийн төвд "Хог шатаах зуух" нийлүүлэх (ӨВАНТСЗДТГ202321702)дугаартай тендерийг 17,000,000 (арван долоон сая) төгрөгөөр "Товуу Сүмбэр сервис" ХХКомпаниар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Гэрээ байгуулан ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авч ажиллахыг Сумын Эрүүл мэндийн төвийн даргыг түр орлон гүйцэтгэгч (Б.Бат-Эрдэнэ), нярав (А.Энхбаатар) нарт даалгасугай.

3.Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Пүрэвдавга)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.СУГАР

622311131

D.My:Doc.A4Zahiramj /ZD/